



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Боловсрол, соёл, урлагийн газрын
2016 оны үйл ажиллагаа, үр дүн**

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙГ
ХАНГАЛТГҮЙ ХӨТӨЛСӨН БАЙНА**

Өлгий сум

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар Тэргүүлэх аудитор М.Хуанган Аудитын менежер Х.Женисбек Аудитын баг Аудитор Б.Үүрийнтуяа Аудитор Х.Еркебулан 2017 оны 6 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 89838414 дугаарын утсаар хандана уу. Хаяг: Аймгийн ЗДТГазрын байр 1-давхар	Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5 Бүлэг-1 БСУГазрын 2016 оны үйл ажиллагааны үр дүнгийн талаар - Тайлант онд төлөвлөсөн ажлуудыг 95,1 хувьтай хэрэгжүүлсэн байна. - Боловсролын салбарын чиглэлээр төлөвлөгдсөн ажлууд бүрэн хийгджээ. 6 - Соёл урлагийн чиглэлээрх ажлууд хэрэгжсэн байна. 7 Бүлэг 2. Батлагдсан төсөв, хөрөнгийн зарцуулалтын талаар - Тайлант оны батлагдсан төсөв үндэслэлтэй хийгджээ. 8 - Төсвийн зарцуулалтанд тавих дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна. 9 - Орон тоо, бүтцийг шинээр зохин байгуулж, цалингийн шатлал, нэмэгдлийг журмын дагуу олгожээ. 9-10 - Нэмэлт төсвийг зарцуулалтын эрхийн дагуу зориулалтаар нь зарцуулжээ. 10 2016 оны санхүүгийн тайланг стандарт, заавар журмын дагуу бүрэн гүйцэд гаргаагүй байна. 11 - Өм хөрөнгөнд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. 11 - Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн байна. 12 Дүгнэлт.....13 Зөвлөмж15 14 Холбогдох байгууллагын санал.....16 Саналд өгсөн тайлбар.....
---	--

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхий аудитор 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалагаар Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Боловсрол, соёл, урлагийн газрын 2016 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, гарсан зөрчил, дутагдлуудыг арилгах, цаашид засаж сайжруулах санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Боловсрол, соёл, урлагийн газрын 2016 оны үйл ажиллагаа үр дүнтэй эсэх
- Төсвийн төлөвлөлт, хөрөнгийг зарцуулалт үр ашигтай эсэх
- Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд тавих дотоодын хяналт үр нөлөөтэй эсэх

Хамрах хүрээ:

Аудитыг БСУГазрын 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээ, холбогдох бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

Аудит хийгдэх асуудлын талаархи товч мэдээлэл:

Боловсрол, соёл, урлагийн газар нь 2016 онд 305.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 304.9 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулжээ. Нэмэлт санхүүжилтээр 184.3 сая төгрөгийн, Орон нутгаас 93,5 сая төгрөгийн, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 1,9 ая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд тусгагдсан аудитын арга зүйг ашиглан холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан, хариуцсан мэргэжилтэнүүдтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, эрх зүйн байдлыг бодит байдалтай харьцуулах, байгууллагын үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр болон аудитын горимын дагуу

нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана.Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Шилэн дансны тухай хууль

Аудитын хугацаа, багийн бүрэлдэхүүн

Аудитыг 2017 оны 05 дугаар сарын 08-ний өдрөөс 6 дугаар сарын 09-ны хооронд аудитор Б.Үүрийнтуяа ахалж, шинжээч К.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хуваарийн дагуу хийж, тайланг бэлтгэв.

Бүлэг 1

**Тайлант онд төлөвлөсөн ажлуудыг 95,1 хувьтай
хэрэгжүүлсэн байна.**

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар нь хуулиар олгогдсон эрх үүргийнхээ дагуу боловсрол, соёл, урлагийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчилах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, орон нутгийн бодлого, чиглэлийг тодорхойлох, стратегийн төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлэх гол зорилготой байгууллага юм.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/556 тоот захирамжаар Боловсролын газрын нэрийг Боловсрол, соёл, урлагийн газар болгон өөрчилж, бүтэц зохион байгуулалт, орон тоог шинэчлэн тогтоосон байна. Шинэ бүтцээр тус газар нь Мэргэжил арга зүйн нэгж, Төрийн захиргаа аж ахуй нэгж гэсэн үндсэн 2 нэгжид хуваагдсан бүтэц зохион байгуулагджээ.

Боловсрол, соёл, урлагийн газрын 2016 оны үйл ажиллагааны үр дүнгийн талаар

Боловсролын салбарын чиглэлээр төлөвлөгдсөн ажлууд бүрэн хийгджээ.

Тус газар нь 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндсэн 4 зорилтын хүрээнд 102 заалт бүхий ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97 ажил бүрэн хэрэгжиж, гэрээний биелэлт 95,1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

БСУГазар нь туршилт, судалгаа-шинжилгээ арга зүйн төв тул дэргэдээ ердийн, гүнзгийрүүлсэн, төрөлжсөн сургалт эрхэлдэг түшиц сургууль, цэцэрлэгүүдтэй байх ёстой гэсэн шаардлагын дагуу дээрх асуудлууд цогцоор шийдэгдэх тусдаа байртай болох яригдаж байна. Иймээс 2016 онд аймгийн Засаг даргын дэмжлэгээр тус газрын нэр дээр эзэмшлийн 512 м/кв газрыг авсан ба цаашид цогцолбор барих талаар хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр асуудлыг БШУСЯаманд тавьсан байна.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгүүдийн захирал, эрхлэгч, Соёл урлагийн салбарын байгууллагын дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр дүгнэж ажилласан байна. 2015-2016 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай холбоотой 12 төрлийн зорилт дэвшүүлж, зорилт тус бүрээр ажлууд хийгджээ.

2014-2015 оны хичээлийн жилээс хойш Боловсролын салбарт “Хүүхэд бүрийг хөгжүүлэх боловсролын чанарын шинэчлэл хийгдэж, бага боловсролыг эх хэлний суурь чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх үе” хэмээн тодорхойлж, цөм хөтөлбөрийн

ажлыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүнтэй уялдан БШУСайдын “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх тухай” албан даалгаварын хүрээнд БШУЯамны хүүхэд бүрийг хөгжүүлэх хичээл, үйл ажиллагааны туршлага солилцох зөвлөгөөнийг орон нутагт 4 үе шаттайгаар зохион байгуулсан байна.

Аймгийн боловсролын газрын даргын 64 тоот тушаалаар Бүсийн туршлага солилцох зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан 8 бүсэд улирал бүр зөвлөгөөнийг зохион байгуулж, шалгарсан сайн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт, бичлэг, сайн туршлагын илтгэлийг аймгийн Боловсролын цахим хуудсанд байршуулж нийт багш нарын хүртээл болгосон байна.

Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах зорилгоор ДЗОУБ-ын дэмжлэгээр туслах багш нарыг чадваржуулах, хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн сургалтын стандартыг төрийн өмчийн цэцэрлэгийн стандарттай ижил хэмжээнд хүргэх, гэр цэцэрлэгт малчдын хүүхдийг улирлын чанартай сургалтанд хамруулах зэрэг ажлууд хийгдсэн байна. Аймгийн хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилд 43 цэцэрлэгт 6701 хүүхэд хамрагдсан 2015-2016 оны хичээлийн жилтэй харьцуулахад хүүхдийн 109 өссөн байна.

Соёл урлагийн чиглэлээрх төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжсэн байна.

Соёл урлагийн салбар нь 2016 оны хоёрдугаар хагасаас тус газрын харъяалалд шилжиж ирсэн бөгөөд оны эхэнд үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдсэн байна.

Орон нутгийг судлах музей нь орон нутгийн иргэдийн түүх, соёл, танин мэдэхүйг дээшлүүлэх зорилгоор тайлант онд 3 үзэсгэлэн гаргаж, үзэсгэлэнг ард иргэд болон сургуулийн насны 3000 гаруй хүүхэд үзэж сонирхсон байна.

Аймгийн Хөгжимт драмын театрыг М.Хурманханы нэрэмжит болгож 2016 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Жилийн турш Улаанбаатар хотоос 5, театрын уран бүтээлчдийн 25 тоглолт авч давхардсан тоогоор 35845 ард иргэдэд урлагаар үйлчилсэн байна. Сумдын соёлын төвүүд жилийн турш баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдийг ЗДТГазар болон баг, байгууллагуудтай хамтран төрөл бүрийн урлаг, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллажээ.

Бүлэг 2

Нягтлан бодох бүртгэлийг хангалтгүй хөтөлсөн байна.

2. Батлагдсан төсөв, авсан санхүүжилтийн зарцуулалтын талаар.

Тайлант оны батлагдсан төсөв үндэслэлтэй хийгджээ.

Боловсрол, соёл, урлагийн газрын тайлант оны үйл ажиллагааны төсөв анх 263,8 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд төсвийн тодотголоор 305,4 сая болж 41,6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тэтгэвэрт гарсан нэг удаагийн тэтгэмжийн дүнгээр нэмэгдсэн байна. Тус газрын батлагдсан төсөв өмнөх онд 303,8 сая төгрөгөөр батлагдсанаас тайлант он 1,6 сая төгрөгөөр өссөн байна.

Батлагдсан төсвийн зарлагын өсөлт, бууралт авч үзэхэд: цалин хөлс, НДШ, хангамж, нормативт зардал, урсгал зардал, томилолт, хичээл практикийн зардлууд буурч, байршилтай холбоотой зардал, нормативт зардал, тэтгэмжийн зардлууд өссөн байна.

/Хүснэгтээр харуулбал/

Үзүүлэлт	харьцуулалт		Өсөлт /бууралт
	Өмнөх он	Тайлант он	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	303,814,400.00	305,376,500.00	1,562,100.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,432,900.00	189,584,200.00	(10,848,700.00)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	22,047,600.00	20,854,300.00	(1,193,300.00)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,567,800.00	21,819,800.00	252,000.00
Хангамж, бараа материалын зардал	5,961,700.00	5,915,000.00	(46,700.00)
Нормативт зардал	142,800.00	196,900.00	54,100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	960,000.00	561,500.00	(398,500.00)
Томилолт, зочны зардал	7,398,300.00	3,934,600.00	(3,463,700.00)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлб	183,400.00	91,700.00	(91,700.00)
Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000.00	14,861,300.00	(10,138,700.00)
Бусад урсгал шилжүүлэг	20,119,900.00	47,557,200.00	27,437,300.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуул	450,000.00	450,000.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтг	19,669,900.00	47,107,200.00	27,437,300.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	303,814,400.00	305,376,500.00	1,562,100.00
Улсын төсвөөс санхүүжих	303,814,400.00	305,376,500.00	1,562,100.00

Нягтлан бодох бүртгэлийг хангалтгүй хөтөлсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 304,7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, зарлага санхүүжилт хийгдэж батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.

Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт хэмнэлт
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	305,376,500.00	304,737,400.00	639,100.00
УРСГАЛ ЗАРДАЛ	305,376,500.00	304,737,400.00	639,100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	257,819,300.00	257,630,400.00	188,900.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,584,200.00	189,584,200.00	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	20,854,300.00	20,854,300.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,819,800.00	21,819,800.00	-
Хангамж, бараа материалын зардал	5,915,000.00	5,915,000.00	-
Нормативт зардал	196,900.00	196,900.00	-
Эд хогшил, урсгал засварын зардал	561,500.00	372,600.00	188,900.00
Томилолт, зочны зардал	3,934,600.00	3,934,600.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлб	91,700.00	91,700.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	14,861,300.00	14,861,300.00	-
Бусад урсгал шилжүүлэг	47,557,200.00	47,107,000.00	450,200.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуул	450,000.00		450,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтг	47,107,200.00	47,107,000.00	200.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	305,376,500.00	304,737,400.00	639,100.00
Улсын төсвөөс санхүүжих	305,376,500.00	304,737,400.00	639,100.00

Урсгал засварын зардлыг 0,2 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлж, ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал 0,5 сая төгрөгийг дутуу ирсэнээс төсөв нийт дүнгээр хэмнэлттэй харагдаж байна.

Нийт төсвийн 189,6 сая төгрөгийг буюу 62,2 хувийг цалин хөлсний, 20,9 сая төгрөгийг буюу 6,8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн, 47,2 сая төгрөгийг буюу 15,5 хувийг бараа, үйлчилгээний зардал, 47,1 сая төгрөгийг буюу 15,4 хувийг тэтгэвэр тэтгэмжийн зардалд зарцуулжээ.

2016 онд шатахууны зардал 2,3 сая төгрөг зарцуулж, шатахуун зарцуулалтын тооцоог сар бүр хийж, үлдэгдлийг баталгаажуулжээ.

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд нийт 47,1 сая төгрөг батлагдсаныг 3 хүнд 44,6 сая төгрөгийн тэтгэмжийг олгож, 1,1 сая төгрөгийг 2017 онд тэтгэвэрт гарах 1 хүний тэтгэмжийн урьдчилгаанд олгожээ. 1,4 сая төгрөгийг ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмжинд төрийн сангийн зөвшөөрөлгүйгээр зориулалт бусаар зарцуулсан тул албан шаардлага өгөгдөв.

Тэтгэвэрт гарсан ажилчдын анхан шатны баримтыг шалгаж үзэхэд тус газарт манаачаар ажиллаж байгаад тэтгэвэр тогтоолгох өндөр насны хязгаарт хүрээгүй үедээ нас барсан хүнд Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-ийн “Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн”, 24.1.2-т “Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн”, Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын 2¹-д “Боловсролын тухай хуулийн 43.1.4, 43.5-т заасан төрийн үйлчилгээний албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж тооцох цалингийн хэмжээг энэ журмын 3, 4 дэх заалтад заасны дагуу тогтоох бөгөөд тэдгээрийн ажилласан хугацаанд Боловсролын тухай хуулийн 3.1.15, 43.1.2-т заасан төрийн үйлчилгээний албан тушаалд ажилласан хугацаа болон энэ журмын 5.4-5.8-д заасан хугацааг оруулан тооцно. Мөнгөн тэтгэмжийг энэ журмын 6-10-т заасныг баримтлан олгоно”, журмын 10-т “Өндөр насны тэтгэврээ албан ёсоор тогтоолгож, ажил олгогчид өргөдөл гаргасных нь дараа энэ журамд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж үндсэн цалинг 18 сараар тооцож 7,4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг олгожээ.

БСУГазрын дарга Х.Зауре нь миний бие 2016 оны 9 дүгээр сард тус газрын даргаар томилогдсон ба 7,4 сая төгрөгийн тэтгэмж Сангийн яамнаас 10 дугаар сард төсвийн хуваарийн дагуу орж ирснийг олгосон. Тус газрын өмнөх дарга, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч нар 2016 оны 4 дүгээр сард төсвийн тодотголоор оруулж батлуулсныг баримт материалыг нягтлаагүй олгосон нь миний алдаа гэсэн тайлбар өгсөн.

Энэхүү тэтгэмжийг авсан хүн нас барж, хариуцах эзэнгүй болсон тул зөрчилд тооцож, цаашид анхаарч ажиллах талаар албан шаардлага өгөв.

Орон тоо, бүтцийг шинээр зохион байгуулж, цалингийн шатлал, нэмэгдлийг журмын дагуу олгожээ.

Аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/556 тоот захирамжаар Боловсрол, соёл, урлагийн газрын бүтэц зохион байгуулалт, орон тоог шинэчлэн тогтоосон байна. Тус газар нь “Мэргэжил арга зүй”-н нэгж, “Төрийн захиргаа, аж ахуй”-н нэгж гэсэн шинэ бүтэцтэй болж Мэргэжил арга зүйн нэгжид 16, Төрийн захиргаа, аж ахуйн нэгжид 15 орон тоо, газрын дарга нийтдээ 32 орон тоо батлагджээ.

Орон тоог 7-гоор нэмж баталсан боловч цалингийн сан нэмэгдээгүйгээс өмнөх 27 орон тоогоор ажилласан байна.

Тус газрын цалингийн сангийн зарцуулалт, цалин тогтоолт, нэмэгдлийг Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоол, байгууллагын даргын тушаал, шийдвэр, санхүүгийн бусад баримт, материалуудыг үндэслэн шалгаж үзэхэд зөрчил дутагдал гараагүй журмын дагуу олгогдсон байна.

Ажилчин, албан хаагчдын цалин хөлс, урьдчилгааг ХААН банкин дахь цалингийн дансаар тавьж олгосон ба цалингийн цэсэнд гарын үсэг зуруулаагүйг зөрчил тооцож аудитын явцад албан шаардлага өгөгдөв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 3 дугаар 3-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Land-100 маркийн автомашиныг ЗДТГазрын балансаас шилжүүлэн авч 32,5 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгажээ.

Нэмэлт төсвийг зарцуулалтын эрхийн дагуу зориулалтаар нь зарцуулжээ.

Тайлант онд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 279.7 төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулснаас 186,2 сая төгрөгийг БСШУСЯамнаас, 90,0 сая төгрөгийн хуваарилагдаагүй зардлаас, 3,5 сая төгрөг бусад орлогоос авч зарцуулжээ.

Дээрх зардлуудыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр авч үзэхэд яамнаас ЕБСургуулиудад олгох нэмэлт төсөв, хөрөнгө оруулалт тээврийн хөлс, сургалт семинарын зардлуудад зарцуулсан байна.

Орон нутгийн хуваарилагдаагүй зардлыг нэмэлт төсвийн зарцуулалтын эрхтэйгээр салбарын чиглэлээр олимпиадын замын зардал, тээврийн хөлс, сургалт семинарын зардалд 56,5 сая төгрөгийг, Дээд шүүхийн тогтоолоор мэргэжилтэн Р.Серикболын ажилгүй байсан хугацааны цалинд 15,8 сая төгрөгийг, сургалтын заалны тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ариун цэврийн өрөөний засварт 10,0 сая төгрөгийг, балансаас балансад шилжүүлэн авсан автомашины урсгал засвар, үйлчилгээнд 7,6 сая төгрөгийг тус тус зарцуулж, аймгийн ИТХ-ын тогтоолыг үндэслэн Засаг даргын захирамж гаргуулж, нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүснэгтээр зохих зөвшөөрлөөр зарцуулжээ.

3. Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд тавих дотоодын хяналтын талаар

2016 оны санхүүгийн тайланг стандарт, заавар журмын дагуу бүрэн гүйцэд гаргаагүй байна.

БСУГазар нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3-д заасан хугацаанд баталгаажуулалт хийлгэхээр Аудитын газарт ирүүлээгүй ба санал дүгнэлт өгөхөөс татгалзаж, нягтлан бодогчийг ажлаас халах санал хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад 2016 оны санхүүгийн тайланг стандарт, заавар аргачлалын дагуу үнэн зөв гаргасан эсэхийг баталгаажуулалт хийхэд оны эцэст харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоог хийж, тооцооны үлдэгдлийг баталгаажуулагүй байна. Тухайлбал: ажиллагсадын цалингаас суутгасан ХХОАТатварын тооцоог хийж үзэхэд тайлант оны тооцоогор 1477,7 мянган төгрөгийн дутуу төлөлттэй гарсныг жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй нь ХХОАТатварын тухай хуулийн 26.1.1, 18.1.6, 29.1.5, Төсвийн тухай хуулийн 16.5.7, 26.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016 оны 6 дугаар 6-ны өдрийн 71 тоот тогтоолоор тус газрын сургалтын зааланд авсан 900,0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг данс бүртгэлд орлого авч, санхүүгийн тайланд тусгаагүй байна. Дээрх зөрчлүүдийг эхний хагас жилийн санхүүгийн тайланд тусгаж, залруулахыг албан шаардлагаар үүрэг болгов.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 279,8 сая төгрөгөөр буюу нэмэлт санхүүжилтийг цэвэрлээгүй дүнгээр зөрүүтэй гаргаж Төсвийн тухай хуулийн 6.3.2, 6.3, 16.5.7, 41.2.3, Сангийн Сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн гүйцэтгэл тайлан боловсруулах журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Тус газрын касс, харилцахын анхан шатны баримтыг төрийн сангийн дансны хуулга, орлого, зарлагын гүйлгээ бүрээр тулгаж шалгаж үзэхэд жилийн турш 7,3 сая төгрөгийг бэлнээр зарцуулсан боловч кассын тайлан гаргаагүй, төлбөрийн хүсэлтийн баримтанд хавсаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1, 13.7, 14-р зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 14.3.4 дэх заалтуудыг хангаж ажиллаагүй байна. Мөн бараа материалын тайланг өмнөх оны эхний, эцсийн үлдэгдэлд хөдөлгөөн гараагүйгээр тайлагнаж, аж ахуй, бараа материалын тайланг гаргуулж тооцоо хийгээгүй, бараа материалын нийтдээ **39,0** сая төгрөгийн зарлагыг шууд зардлаар бүртгэж НББ-ийн тухай хуулийн 8.2, Төсвийн тухай хуулийн 6.3.2, 16.5.7, 26.1 дэх заалтуудыг зөрчиж ажилласан байна.

Нягтлан бодогчоор ажиллаж байсан Х.Мендибай нь ажлаас халагдсан тул алдаа зөрчлийг цаашид анхаарч ажиллах талаар албан шаардлага өгөв.

Байгууллагын даргын 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 75 тоот тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, тооллогын комисс нь тооллогын үр дүнгийн талаар илтгэх хуудас бичиж, хөрөнгийн тооллогын бүртгэлд гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

Эд хөрөнгийн тооллогоор элэгдлийн хугацаа дуусч ашиглагдахгүй болсон олон жил ашиглагдсан 29590,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1519,4 мянган төгрөгийн бараа материалыг актлуулахаар санал оруулсан боловч шийдэгдээгүй, 2017 оны эхний хагас жилд Орон нутгийн өмчийн газарт хүсэлт гаргаж, данснаас хасахаар холбогдох материалыг хүргүүлсэн байна.

4.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн байна.

Тус Аудитын газраас 2016 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн данс шинэчлэгдсэнтэй холбоотой 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бусад мэдээллийг бүрэн байршуулаагүйгээс хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн нягтлан бодогч Х.Мендибайд арга хэмжээ тооцогдсон байна.

Аудит хийх явцад байгууллагад шилэн дансны мэдээллийн самбарт мэдээлэл байршуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж үзэхэд шилэн дансны мэдээллийн самбарыг тусдаа хийлгээгүй, шилэн дансны веб сайтанд шинээр томилогдсон дарга, нягтлан бодогчийн нэрийг засаж оруулаагүй, байгууллагын батлагдсан төсвийг бүтэн жилээр оруулаагүй, 2016 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг оруулаагүй зэрэг зөрчил дутагдлууд гарсныг аудитын явцад арилгуулав.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Салбарын чиглэлээрх төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.
2. Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.
3. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
4. Анхан шатны болон нягтлан бүртгэлийн хөтлөлтийг сайжруулах шаардлагтай байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Зөвлөмж өгөгдөөгүй

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
83129 Өлгий, Өлгий сум, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7012-2367
E-mail: bsgbu_edu@yahoo.com, http://www.edu.bo.gov.mn

2014.06.15 № 189

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус газрын 2016 оны санхүүгийн болон бусад баримтуудад гүйцэтгэлийн аудит хууль, журмын дагуу хийгдсэн бөгөөд аудиттай холбоотой санал, хүсэлт байхгүй болно.

ДАРГЫГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЗАУРЕ

